



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/62

Шивээговь сум

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах
 өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан баярын үйл ажиллагааг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр сумын Төв талбайд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Баярын үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, зарцуулагдах зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 1,320,568 (нэг сая гурван зуун хорин мянга таван зуун жаран найм) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

4. Холбогдох арга хэмжээг чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг Соёлын төвийн дарга (Э.Төрмандах), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх) нарт, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ), нярав (Б.Мөнхцэцэг) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д тус тус үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

42122'235


Сумын Засаг даргын
2022 оны 05-р сарын 06-ны
өдрийн 1/69 дугаар захирамжийн 1-р хавсралт



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ БАЯРЫН ӨДӨР-2022 ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа, цаг	Зохион байгуулах газар	Хариуцах нэгж
1	Алдарт эхийн одон гардуулах ёслолын ажиллагаа	2022.05.30	Төв талбайн тайз	ИТХ, ЗДТГ, СОЁЛЫН ТӨВ
2	Нээлтийн арга хэмжээ	2022.06.01	Төв талбайн тайз	Соёлын төв
3	108 ээжийн Сүүн цацал өргөх ёслол	2022.06.01	Төв талбай	Сумын Ахмадын хороо
4	Цэцэрлэгийн хүүхдийн урлагийн номер	2022.06.01	Төв талбайн тайз	Соёлын төв, Ахмадын хороо
5	Авьяастануудын урлагийн номер	2022.06.01	Төв талбайн тайз	3-р цэцэрлэг
6	Дугуйн уралдаан зохион байгуулах	2022.06.01	Төв талбай	Шивээ-Овоо ажилтаны ҮЭ хороо
7	Зургийн уралдаан зохион байгуулах	2022.05.27-31	Цахимаар	Шивээ-Овоо ажилтаны ҮЭ хороо
8		2022.06.01	Төв талбай	Ерөнхий боловсролын сургууль
9	АХА тэмцээн	2022.06.01	Төв талбай	Илчлэг-Шивээ ОНӨҮГ
10	Шивээ-Овоо ХК-ийн нэрэмжит Гэрэлт гудамын нээлт	2022.06.01	Төв талбай	Шивээ-Овоо ХК
11	Нутгийн багачууд баярын нэгдсэн тоглолт	2022.06.01	Төв талбайн тайз	Соёлын төв
12	Хүүхэлдэйн кино гаргах	2022.06.01	Төв талбайн тайз	Шивээ-Овоо ХК

Сумын Засаг даргын 2022 оны
 05-р сарын 26-ны өдрийн А/62
 дугаар захирамжийн 01-р хавсралт



БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Будаг	литр	25	7000	175.000
	Улаан				
	Шар				
	Цэнхэр				
	Ногоон				
	Хар				
2	Жуух бичиг	ширхэг	20	26.000	520.000
3	Туузны уяа	метр	100	2000	20.000
4	Хязгаарлалтын тууз	метр	500	15.000	15.000
5	Аннос /хулдаасан хэвлэл/	430*300	2	172.800	345.600
		400*300	1	161.280	161.280
		Эх бэлтгэл	3	10.000	30.000
	Нийт				1,320,568